

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн..	6
2.8.1.	Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6
2.8.2.	Авлага	7
2.8.3.	Бараа материал	7
2.8.4.	Үндсэн хөрөнгө	8
2.8.5.	Өр төлбөр	8
2.8.6.	Засгийн газрын хувь оролцоо	9
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12.	Шилэн дансны мэдээлэл	10
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3.	Менежментийн захидал.....	12
3.1.	Дотоод аудиттай холбоотой асуудал.....	12
3.2.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн асуудал.....	13
4.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
4.1.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	14
4.2.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	14
4.3.	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.4.	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.5.	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
4.6.	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	16
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ө.ШИЖИР ТАНАА

2020.04.24 № 1318
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Ө.Шижир танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод аудиттай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 06-ны өдрөөс 2020 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Б.Уянга гүйцэтгэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн ТГ/224 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үр бүтээлтэй зохион байгуулж, Ерөнхийлөгчийг үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд цаг үеэ олсон, алсыг харсан, мэргэшсэн зөвлөгөө үйлчилгээгээр хангаж, шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлийн хөтөч байхад оршино.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тамгын газар үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хууль, бусад хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг удирдлага болгон ажилладаг;
- Тамгын газар үйл ажиллагаагаа Ерөнхийлөгчийн бүрэн эрх, бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн зорилгыг биелүүлэхэд чиглүүлж, холбогдох байгууллагуудтай нягт уялдуулан явуулдаг;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2014 оноос хойш өөрчлөлт оруулж, шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай.

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ны “Acoulous” программыг ашиглан боловсруулж, санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ

төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” программ хангамж ашиглан Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг бэлтгэсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт дотоод аудитын чиглэлээр үйл ажиллагаа явуулах үүрэг, чиглэл бүхий албан тушаалтан байхгүй байгаа тул тайлант онд энэ чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй, хийгдсэн ажил байхгүй, өмнөх аудитаар нийт 113.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 1 албан шаардлага өгч, 113.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсний хэрэгжилтийг үнэлэхэд албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөвлөмжийг 33.3 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 31 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБООС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,646.5 сая төгрөгийн 2 хувь буюу 92.9 сая төгрөгөөр тогтоов.

Төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон нь Төсвийн ерөнхийлөн захирагч нь сүүлийн 3 жил зөрчилгүй санал дүгнэлт авч байсан тул санхүүгийн үйл ажиллагааг эрсдэл багатай гэж үзсэнтэй холбоотой болно.

2.8. Аудитын хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1. Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 0.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.1	0	-0.1
Банканд байгаа бэлэн мөнгө	0.0	0	0.0
Дүн	0.1	0	-0.1

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар нийт 24.8 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан./Ерөнхийлөгчийн Тамгын газар 9.7 сая, Ерөнхийлөгчийн төсөв 15.1 сая/;
- Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрүүлж нийт 36.4 сая төгрөгийг бүртгэсэн./Ерөнхийлөгчийн Тамгын газар 1.3 сая, Ерөнхийлөгчийн төсөв 35.1 сая/;
- Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны шууд захирагч өөртөө 0.4 сая төгрөгийн урамшуулалт цалин олгох тушаал гаргасан, ажлын хоногийг буруу тооцон 0.3 сая төгрөгийн цалин илүү олгосон.

2.8.2. Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 3.5 сая төгрөг болж өссөн нь нэр данс зөрүүтэй буцаж орж ирсэн гүйлгээг татан төвлөрүүлснийг Сангийн яамнаас авах авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	0.0	0.0
Татаас, санхүүжилтийн авлага		3.5	3.5
Дүн	0.0	3.5	3.5

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.3. Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 375.5 сая, эцсийн үлдэгдэл 470.4 сая төгрөг болж, 94.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материал дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	186.4	237.8	51.4
Бэлэн бүтээгдэхүүн	162.8	175.0	12.2
Бусад хангамжийн материал	26.3	57.6	31.3
Дүн	375.5	470.4	94.9

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд тусгай зориулалттай материал өмнөх оноос 27.6 хувиар буюу 51.4 сая, бэлэн бүтээгдэхүүн 7.5 хувь буюу 12.2 сая, бусад хангамжийн материал 2 дахин буюу 31.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь одон медаль, гадаад зочид төлөөлөгчдөд олгох бэлэг дурсгалын зүйл худалдан авсантай холбоотой байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-д

“Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааг явуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалын дансанд нийт 11 нэр төрлийн 9.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн./Ерөнхийлөгчийн Тамгын газар 5.3 сая, Ерөнхийлөгчийн төсөв 4.2 сая/;
- Ерөнхийлөгчийн Тамгын газар 3.9 сая төгрөгийн бараа материалыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэж тайлагнасан.

2.8.4. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,255.9 сая, эцсийн үлдэгдэл 1,268.2 сая төгрөг болж, 12.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт№4 Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	871.0	879.0	8.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	355.8	360.1	4.3
Бусад үндсэн хөрөнгө	21.1	21.1	-
Ном	8.0	8.0	-
Дүн	1,255.9	1,268.2	12.3

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Ерөнхийлөгчийн Тамгын газар төсвийн хөрөнгөөр 2.1 сая төгрөгийн камер, 5.9 сая төгрөгийн өнгөт принтер, Ерөнхийлөгчийн төсвөөс албан хэрэгцээнд 4.3 сая төгрөгийн сандал, буйдан тус тус бэлтгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс нь үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын илтгэх хуудсыг хангалтгүй хийсэн, тооцоог бодож, үлдэгдлийг актаар баталгаажуулаагүй байна.

2.8.5. Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1.7 сая, эцсийн үлдэгдэл 4.6 сая төгрөг болж, 2.9 сая төгрөгөөр өссөн нь нэр данс зөрүүтэй буцаж орж ирсэн гүйлгээг өглөгөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт№5 Нийт өр төлбөр дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Ажилчидтай холбогдсон өглөг	-	1.1	1.1
Байгууллагад төлөх өглөг	1.7	3.5	1.8
Нийт дүн	1.7	4.6	2.9

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.6. Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 719.9 сая, эцсийн үлдэгдэл 737.6 сая төгрөг болж, 17.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

Хүснэгт№6 Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	419.3	419.3	-
Хуримтлагдсан үр дүн	284.1	301.8	17.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16.5	16.5	-
Дүн	719.9	737.6	17.7

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан урсгалд зардалд 4,624.6 сая төгрөгийн төсөв батлагдсаныг улсын төсвөөс 100.0 хувь санхүүжүүлсэн байна.

Тайлант онд урсгал зардлын гүйцэтгэлээр материаллаг дүнтэй хэмнэлт, хэтрэлт гараагүй бөгөөд, батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

Төсвийн урсгал зардалд 4,618.8 сая төгрөг зарцуулж, 5.8 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Засгийн газрын нөөц сангаас Ерөнхийлөгчийн Тамгын газарт “Атарчдын алдар” медаль, үнэмлэх үйлдвэрлэхэд шаардагдах 32.0 сая, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албанд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харьяа Соёл урлагийн газраас “Үндэсний бичиг үсгийн баяр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний зардалд 2.0 сая, Барилгын хөгжлийн төвөөс “Барилгын салбарын нэр томъёог шинэчлэх” толь бичгийг хянах зардалд 3.2 сая төгрөгийн санхүүжилт авч нийт 37.2 сая төгрөгийг зарцуулсан.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 төсвийн байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 77.5 сая төгрөгийн алдаа,

зөрчил илрүүлснээс 2.3 сая төгрөгийн алдааг залруулж, 75.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 12 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 2.3 сая төгрөгөөр авлагыг дутуу нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 32.0 сая төгрөгөөр тусламж, санхүүжилтийн орлого болон бараа үйлчилгээний зардлыг илүү, үйл ажиллагааны үр дүнг 2.3 сая төгрөгөөр дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд 2.3 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүн дутуу нэгтгэсэн;

Төсвийн ерөнхийлөн захирагчийн алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын харьяа 3 төсвийн байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, аудитаар нийт 75.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэнд 10 зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын санхүүгийн тайлангийн дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 100 мэдээллийг хугацаанд нь, 49 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Дараа жилийн төсвийн төсөл, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 113.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 1 албан шаардлага өгч, 113.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсний хэрэгжилтийг үнэлэхэд албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөвлөмжийг 33.3 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Залруулагдаагүй 75.2 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 92.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул Зөрчилгүй дүгнэлтийг өгч байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Дотоод аудиттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Төрийн аудитын байгууллагаас өмнөх аудитаар нийт 113.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 1 албан шаардлага өгч, 113.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсний хэрэгжилтийг үнэлэхэд албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөвлөмжийг 33.3 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 6 дугаар зүйлийн 6.3.5-д "шалгалтын дүнд тулгуурлан гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, зохих журмын дагуу биелэлтийг хангуулах арга хэмжээ авах", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын хяналт хэрэгжүүлээгүйгээс алдаа зөрчил гарах, хууль тогтоомж, дүрэм журмын зөрчигдөх, зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилт хангалтгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн үйл ажиллагааг эрсдэлийн удирдлагаар хангах, дотоод аудитыг хэрэгжүүлэх, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг тооцож ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Байгууллагын удирдлага өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрч хариу ирүүлсэн.

3.2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль, дүрэм, журмын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт, шинэчлэн боловсруулалт хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", УСНББОУС-3 "Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа 17.Байгууллага зөвхөн дараах тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчилж болно. ...б) Байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл эсвэл мөнгөн гүйлгээний тайланд үзүүлэх ажил гүйлгээ, бусад үйл явдал эсвэл нөхцөл байдлын нөлөөний талаар илүү найдвартай бөгөөд хамааралтай мэдээлэл санхүүгийн тайланд бий болгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль эрх зүйн акт зөрчигдөх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан стандарт, журамтай нийцүүлэх, өөрийн байгууллагын онцлогт тохирч өөрчлөлт оруулах зөвлөмж өгөх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Байгууллагын удирдлага өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрч хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	375,644.5	473,882.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	132.0	0.0
33	АВЛАГА	0.1	3,523.7
35	БАРАА МАТЕРИАЛ	375,512.4	470,359.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	345,942.1	268,228.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	345,942.1	268,228.3
39200	Биет хөрөнгө	345,942.1	268,228.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	721,586.6	742,111.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,730.3	4,526.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,730.3	4,526.3
41300	Өглөг	1,730.3	4,526.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	719,856.3	737,584.7
51	Засгийн газрын хувь оролцоо	719,856.3	737,584.7
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	419,275.6	419,275.6
51200	Хуримтлагдсан үр дүн	284,058.0	301,786.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,522.7	16,522.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	721,586.6	742,111.0

4.2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,460,393.9	4,664,189.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,339.5	2,367.6
120	Нийтлэг татварын бус орлого	2,339.5	2,367.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,458,054.4	4,661,821.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,487,749.3	4,646,461.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,987,749.3	4,646,461.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,773,318.0	4,446,573.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	998,970.8	1,132,176.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,905.2	141,524.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,338.0	7,344.0
2104	Хангамж, бараа материалын зардал	434,710.7	166,563.9
2105	Нормативт зардал	4,950.0	4,861.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,997.9	11,999.9
2107	Томилолт, зочны зардал	1,424,187.8	1,295,824.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,692.7	13,181.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,746,564.8	1,673,096.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	214,431.3	199,887.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	500,000.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-27,355.4	17,728.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-27,355.4	17,728.4

4.3. Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	747,211.8	0.0	747,211.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	747,211.8	0.0	747,211.8
9	Тайлант үеийн үр дүн	-27,355.4	0.0	-27,355.4
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	719,856.3	0.0	719,856.3
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	719,856.3	0.0	719,856.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	719,856.3	0.0	719,856.3
19	Тайлант үеийн үр дүн	17,728.4	0.0	17,728.4
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	737,584.7	0.0	737,584.7

4.4. Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,503,504.4	4,667,641.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,339.5	5,819.4
120	Нийтлэг татварын бус орлого	2,339.5	5,819.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,501,164.8	4,661,821.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,735,662.7	4,655,547.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,735,662.7	4,655,547.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,521,231.4	4,452,208.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	998,290.2	1,131,114.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,905.2	141,583.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,338.0	7,344.0
2104	Хангамж, бараа материалын зардал	431,518.4	162,008.3
2105	Нормативт зардал	4,950.0	4,861.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,997.9	20,823.5
2107	Томилолт, зочны зардал	1,352,451.3	1,273,547.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,692.7	13,381.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,570,087.7	1,697,543.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	214,431.3	203,339.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	767,841.6	12,093.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	768,332.4	12,225.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	768,332.4	12,225.9
2200	Дотоод эх үүсвэрээр	768,332.4	12,225.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-768,332.4	-12,225.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-490.8	-132.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	622.8	132.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	132.0	0.0

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,624,571.9	4,618,759.6	5,812.4	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,624,571.9	4,618,759.6	5,812.4	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,437,994.9	4,432,434.2	5,560.8	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,132,671.0	1,131,114.9	1,556.1	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,583.8	141,583.3	0.5	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,344.0	7,344.0	0.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	162,601.4	162,008.3	593.1	99.6
2105	Нормативт зардал	4,950.0	4,861.9	88.1	98.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,995.3	30,987.4	7.9	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,273,764.6	1,273,547.7	216.9	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,391.9	13,381.6	10.3	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,670,692.9	1,667,605.2	3,087.7	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	186,577.0	186,325.4	251.6	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	186,577.0	186,325.4	251.6	99.9
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,624,571.9	4,618,639.6	5,932.3	99.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,624,571.9	4,618,639.6	5,932.3	99.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		120.0	-120.0	0.0

4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	37,250.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	37,250.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,250.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,250.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	37,250.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,250.0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/1/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга			сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ					
I. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН					
1	Төрийн аудитын байгууллагаас өмнөх аудитаар нийт 113.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 1 албан шаардлага өгч, 113.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсний хэрэгжилтийг үнэлэхэд албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөвлөмжийг 33.3 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.	-	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дэд дарга,	Г.Байгалмаа
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль, дүрэм, журмын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт, шинэчлэн боловсруулалт хийгээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Г.Амгалан
	Дүн	-			
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ					
II. ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТӨСӨВ					
1	Бараа материалын дансанд 4 нэр төрлийн 4.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн, бараа материалыг шаардах хуудсаар зарлагддаггүй байна.	4.2	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дэд дарга,	Г.Байгалмаа
2	Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан.	15.1	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Г.Амгалан
3	Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрүүлж бүртгэсэн байна.	35.0	Зөвлөмж өгөх		
	Дүн	54.3			
III. ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР					
1	Бараа материалын дансанд 7 нэр төрлийн 5.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн, бараа материалыг шаардах хуудсаар зарлагддаггүй байна.	5.3	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дэд дарга, Нягтлан бодогч	Г.Байгалмаа Г.Амгалан

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

A	1	2	3	4	5
2	Бараа материалыг тооцооны дансаар дамжуулаагүй 3.9 сая төгрөгийн 12 ажил гүйлгээг шууд зардалд бүртгэж тайлагнасан байна.	3.9	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дэд дарга,	Г.Байгалмаа
3	Анхан шатны баримтгүй, баримтын бүрдэл дутуу гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан.	9.7	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Г.Амгалан
4	Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрүүлж бүртгэсэн байна.	1.3	Зөвлөмж өгөх		
	Дүн	20.2			
IV.ХЭЛНИЙ БОДЛОГЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА					
1	Ажлын хоногийг буруу тооцон 270.0 мянга төгрөг илүү олгосон байна.	0.3			
2	Төсвийн шууд захирагч өөртөө 384.7 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгох тушаал гаргасан байна.	0.4		ХБҮЗАА-ны дарга,	Н.Нарангэрэл
3	Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс нь үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын илтгэх хуудсыг хангалтгүй хийсэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	-		Нягтлан бодогч	Ж.Наранчимэг
	Дүн	0.7			
	НИЙТ ДҮН	75.2			

5.1. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр			Нийт зөрчил		Залруулсан алдаа		Зөвлөмж	
		Итгэл үзүүлсэн	Түүвэрт	Дүгнэлт	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ										
1	Монгол Ерөнхийлөгчийн газрын дарга	Улсын Тамгын		1	3	2.3	1	2.3	2	-
	ДҮН			1	3	2.3	1	2.3	2	-
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ										
2	Ерөнхийлөгчийн газар	Тамгын	-	1	4	20.2			4	20.2
3	Ерөнхийлөгчийн төсөв		-	1	3	54.3			3	54.3
4	Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын алба		-	1	3	0.7			3	0.7
4	ДҮН		-	3	10	75.2	-	-	10	75.2
	НИЙТ ДҮН		-	3	13	77.5	1	2.3	12	75.2

